

**СОЁЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН
ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Соёлын яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:
 - 2.1. Стратеги, хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар (Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтэс, Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэстэй);
 - 2.2. Төрийн захиргааны удирдлагын газар (Хууль, эрх зүйн хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй);
 - 2.3. Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
 - 2.4. Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
 - 2.5. Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
 - 2.6. Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Хөрөнгө оруулалтын хэлтэстэй);
 - 2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.
3. Соёлын яамны орон тооны дээд хязгаарыг 78 байхаар тогтоосугай.
4. Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.
5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД Ч.НОМИН